



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

᠒᠐᠒᠒ оны ᠐᠒ сарын ᠒8 өдөр

Дугаар ᠕1᠐5

Алтай хот

**Гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2022 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 06 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ГААОНӨГ/202212018 дугаартай Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажлыг "Хайчийн нуруу" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Гаадамба)-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Гаадамба)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  ДАЛТАНЗАГАС

